

**Яруу найраг бүтээх уламжлалт туршлагад
хийсэн ажиглалт**

Р. Бугэрмаа (МУИС)

Монголчууд эртний болон Дундад зууны Энэтхэгийн соёл шинжлэх ухааны алдартай бүтээлүүдийг эх хэлээрээ орчуулан хадгалж ирсэн баялаг өв сантай билээ. Түүний нэг нь эртний Энэтхэгийн утга зохиолын түүхэнд чухал байр эзэлдэг МЭ-ний VII-VIII зууны үед зохиогдсон Дандийн "Зохист аялгуун толь" ерөнхийдөө хүний дотоод сэтгэлийн хөдөлгөөнийг нарийн нээх арга ухааныг гаргасан уянгын яруу найраг хийгээд яруу найргийг зохиох сонгодог онол журамлал мөн. Энд яруу найраг гэж юу болох, ил ба далд утга, мөн найруулгын арван эрдэм утгын гучин таван чимгийг зүйлчлэн тодорхойлж хэрхэн яруу найруулан гаргах вэ гэдгийн гол гол зарчмуудыг тайлбарлан тодорхойлжээ. Түүнээс гадна нэгэнт бодож боловсруулсан утгыг үгээр хэрхэн дүрслэх болон үгийг хэрхэн сонгож байрлуулах журмыг тодорхойлсон гурван бүлэг бүтээл юм. Дорнын уламжлалт яруу найргийн энэ бүтээлийг баяжуулан, тухайн цаг үеийнхээ аяс амьсгалтай холбон бүтээлчээр ашиглах нь манай үгийн урлагийн дархчуулд нэн ашигтай юм.

1990-ээд оны зарим яруу найрагчид Энэтхэг, Төвдийн гүн сэтгэлгээний утга уянганд уламжлал болсон уран сайхны сэтгэх хэв маяг буюу "Зохист аялгуун толь"-ийн "Сайтар уха чимэг-утпрекса" буюу өтгөс буурлуудын уламжлалт орчуулгаар "Гүтгэх" чимгийг өөрийн уран бүтээлд ашиглах явдал ажиглагдаж байна.

Яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн зарим шүлгүүдийг авч үзье.

Дандийн "Зохист аялгуун толь"-ийн хоёрдугаар бүлэгт "Гүтгэх чимэг гэдэг нь юмс үзэгдлийг өөрийн бодлоор үнэлэн өгүүлэх учир цаад үнэн чанараас гажсан ч байдаг. Тийнхүү гүжирлэн өгүүлснээ илэрхийлдэг" хэмээжээ.

Тэгвэл Х. Гаадан "Зохист аялгуун толийн бичгийн тухай" бүтээлдээ "Зохиолын үзэсгэлэнг нэвтэрхий, тансаг сайхан болгохын тулд, өөрөөр хэлбэл, нэг юмны тухай яруу тод, бусдын сэтгэл хөдлөм сайхан өгүүлэхийн тулд өөр үзэгдэл юмсын шинж төрхтэй холбон өгүүлж уран дүрслэлийг бүтээдэг.

Ингэж уран дүрслэлийг хэлний найруулгад ашиглаж өгүүлэх зүйлийнхээ сайхныг тодруулахад үгийн утгыг шилжүүлэн хэрэглэж, өгүүлэх санаагаа тод болгох журам байх бөгөөд энэ нь зүйрлэл юм"¹ гэжээ.

Гэтэл эрдэмтэн Ш.Гаадамба "Цаад юмаа адилтгаж сэтгэл хөдөлгөм өгүүлдэг учраас уран зүйрлэл болно гээд аливаа нэг зүйрлэлээс энэ бол тийм юм биш, ийм юм гэж зориуд мушгин өгүүлэх аргыг гүтгэн дүрслэх арга гэнэ"² хэмээн бичжээ.

¹ Х. Гаадан. "Зохист аялгуун толин дахь адилтгал, зүйрлэл". УБ, 1987, 2 бүлэг.

Энэ бүхнээс үзвэл "Гүтгэх чимэг" нь үзэгдлийн мөн чанар учир байдлыг уран сэтгэмжээр зориуд гажуудуулан гүтгэж өгүүлэх уран найруулгын арга юм. Жишээ нь: Б.Лхагвасүрэн "Тэр хөх мөнхийн уул миний хүүгийн уул" шүлэгтээ:

Тэлмэн зэрэглээн дунд
Эмнэг адуу шиг цовхчих
Тэр хөх мөнхийн уул
Миний хүүгийн уул...
Дэргэдүүр нь дуулж өнгөрсөн
Дуулж байна лээ...
Дэргэдүүр нь уйлж өнгөрсөн

Уйлж байна лээ...³ гэж бичжээ. Уг шүлэгт уул тал хосолсон Монгол орны байгалийн онцлог, адуун сүрэг, ус нутгаа дээдлэх Монгол хүний сэтгэлгээ, зан заншил тод харагдах бөгөөд хүүгээ төрөхөд нь адуунаасаа унага ногтолж өгөөд бага санагдахаар нь "хөхөмдөг униарт талын хаяанаас "Дөл" шиг цоролзох хөх уулыг чиний уул" гэж зааж өгсөн аавын сэтгэлийн тухай өгүүлсэн байдаг.

Энд сая төрсөн нялх хүүдээ эр хүний хийморь болсон морин эрдэнийг зүслэн өгч сайн сайхныг бэлгэдсэн монгол эр хүний сэтгэлийн сайхныг харуулахын зэрэгцээ "Энэ эх орон монгол нутаг чиний юм шүү. Эх орон байгалиа чи нүдний цөцгий мэт хайрлах хэрэгтэй. Чамайг сайн явбал эцэг эх, төрөл садан чинь төдийгүй эх орон чинь баярлах болно" гэсэн гүн утга илэрчээ. Энэ утга санааг илэрхийлэхийн тулд яруу найрагч, "амьгүй уулыг амьтай болгон, хүү нь сайн явж байвал уул нь дуулж баярлан, өвгөд буурлаа үдэхэд уул нь уйлж гуниглан буй тухай" гүтгэн өгүүлсэн нь өвөрмөц сонирхолтой болжээ.

Энэ мэтчлэн түүний шүлгүүдийг ажиглан үзвэл, "Зохист аялгуун толь" дахь зарим утгын чимгүүдтэй тохирч байх юм.

Үүнд: "Говь" шүлэгтээ:

Энэ цагийн гандирс
Нуруун дээр нь өндийнө болохоор
Зэрэглээ нь хүртэл дэвхэцнэ...
Эрт галбын зүүд
Элгэн доор нь үнэгчилнэ болохоор
Элс нь үргэлж хөдөлнө...
...Өрсөн тоглоомыг минь
Хоногтоо залгидаг
Манхан...

... Хөхөмдөг цэнхэр зэрэглээ
Хөөцөгдөн тоглосон
Цайдам...⁴ гэж говь нутгийн тухай өгүүлсэн

байна. Энэ шүлгийг тайлбарлахын тулд Лувсанжамцын "Зохист аялгуун толь"-ийн эхэд буй нэгэн жишээг авч үзвэл:

Сайтар айлдлын цагт уул цэцэрлэгт
Сайн билгийн мөрөн гол урсгаж
Сайн амгалангийн анхилуун үнэр гарган

Саар хувьтны энэллийг арилгагч нарийн биет... хэмээгээд ялгалын уг болох чиний нүүр цэцгийн хүрээний дүрсээр дүрслэгдэж, нүүрийн ялгалт гишүүн болох хөмсөг нь ороонго модны дүрстэй болоод, ороонго мод цааш нь бүжигч эхийн дүрсээр дүрслэгдэн гунхалзаж цэнгэн баясаж бүжиглэв ээ гэж үлгэртнийг цааш дүрсэлсэн нь дүрстний дүрст чимэг болой гэж тайлбарлажээ.

² Х. Гаадан. "Зохист аялгуун толин дахь адилтгал, зүйрлэл". УБ, 1987.

³ Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991. Хуудас 18.

⁴ Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991: Хуудас 11.

Эндээс "Говь" шүлгийг бичсэн бичлэг нь дээрх чимэгт тохирч байна гэсэн дүгнэлтийг хийж болох юм. Учир нь "халуун хүйтэн нь орчилдож тогтсон, хатуу нь зөөлөндөө дийлдэж бүрэлдсэн говь нутгийн гандирсан хот нуруун дээр нь өндийдөг болохоор зэрэглээ нь хүртэл дэвхцэж, эртний зүүд нь элсэн доороос үнэгчилдэг болохоор элс нь хөдлөх бөгөөд сарны мэлмэрээнд уяран шөнөжин дуулж, нарны цацраанд асан өдөржин дүрэлзэж, хүүхэд багачуудын өрсөн тоглоомыг хоногтоо залгиж, хөх тэнгэрээ газарлан одод нь асгарсан" яруу найрагчийн өөрийнх нь өгүүлснээр "миний" бас та бидний элсэн өөжин амьд гучин гурван говийг нэгэнт дүрсэлсэн зүйлээсээ цааш ургуулан дүрсэлсэн болохоор уг шүлгийг уншмагц говь нутаг, байгаль, говийн хүмүүсийн амьдрал, зан заншил сэтгэлд буухуйцаар тод зурагдсан нь онцлогтой юм.

Эрдэмтэн Х. Гаадан "Зохист аялгуун толийн чимгийн тухай" номынхоо хоёрдугаар бүлэгт "Дүрслэгдэхүүний бие үр хоёрын аль алийг нь гаргах боловч дүрслэгдсэн шалтгааныг заавал гаргадаг чимгийг шалтгааны дүрст чимэг гэнэ"⁵ гэж шүлгийг яруу болгох нэгэн чимгийн тухай өгүүлжээ. Тэгвэл одоо "Бидэн хоёр" шүлгийг ажиглаад үзье. Яруу найрагч шүлэгтээ хайр сэтгэлт хоёр залууг нэгнийх нь сүүдэр нөгөө дээрээ тусаж, "од мичид тэнгэрээр шидэлцэн тоглосон" уулс, "талын намуунд мэлмэрч тааралдсан чулуунд харгиатсан" гол мөрөн болгож, амьгүйчлэн гүтгэхдээ, чухам яагаад уулс, гол мөрөн болох гэсэн шалтгааныг:

... Холхон явья даа гэх юм чи
Хоёулаа тэгвэл уулс больё
Од мичид тэнгэрээр шидэлцэн тоглосон
Ойрын сэтгэлтэй холын уулс байя . . .
... Уулзахгүй байя гэх юм чи
Ухаант минь тэгвэл мөрөн больё . . .
Урсгал дээрээ нар сарыг хэмхчин тоглож

Уулзахгүй ч уулзахын сэтгэлтэй голууд байя...⁶ гэсэн нь нэлээд сонирхолтой болсон байх юм. Хүн хэдийгээр уулс, гол мөрөн болохгүй ч гэсэн сэтгэлтэй хосууд хол байна гэдэг нь, ялангуяа хайр сэтгэл нь бүтэхгүй хүмүүс уулзаж учирч, амьдарч чадахгүй бол ёстой л "уулзахгүй ч уулзахын" сэтгэлтэй голуудаас ялгаа юун байх билээ. Мөн "Говийн худгийн асгар дээр бичсэн шүлэг"-тээ:

... Цангинатал янцгааж
Таана ганхтал түргиж
Цангасан адуу
Худгийн зүг айсуу . . .
... Энэ олон адууны хөлд гишгүүлчихгүй
Хаана нь явав даа гэлтэй
Ээжийн минь бүүвэйн дуутай

Бага нас минь айсуу...⁷ хэмээн өгүүлжээ. Энэ нь төрсөн нутагтаа эргэн ирсэн залуу эр бэлчээрт буй худгийн дэргэд амран суухуйд худаг руу ус уухаар ирж байгаа олон адууны тухай зураглалаас өөрийн бага насны тухай сэтгэмж рүү шилжин, ээжийн бүүвэйн дуутай хамт байсан балчир нас нь энэ олон адууны хөлд гишгүүлчихгүй хаана нь явав даа гэсэн бодол ургуулан хийсвэрлэснээрээ бясалган гүтгэх чимгийг чадамгай ашиглажээ. Хүүхэд болгон эхээс төрж, ээжийн бүүвэйн дууг сонсон, сургаалаар хүмүүжин сая хүн болдог. Иймд хүн бүхний бага нас ээж шиг нь, ээжийн бүүвэйн дуу шиг нь ариун нандин зүйл билээ. Энд бага нас - өнгөрсөн үеийг одоо үетэй нь чадварлаг холбон өгүүлсэн нь бас л нэг онцлог зүйл юм.

"Үлгэрт нөмөргөсөн хэвнэг" шүлэгтээ:
Үүл үүлийн хөвөөнд
Одод хяраалах шөнөөр

⁵ Х. Гаадан. "Зохист аялгуун толийн дахь адилтгал, зүйрлэл" УБ, 1987, 2 бүлэг.

⁶ Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991. Хуудас 48.

⁷ Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991. Хуудас 17.

Үлгэрт нөмөргөсөн хэвнэг
Үзгээрээ эсгэн зүүдэллээ . . .
Харваж байгаа сүүлт одонд
Хадган хөх бэх сүвлэж
Халхгар өргөн үлгэрийн хэвнэгийг
Хавж суугаад зүүдэллээ...⁸ яруу найрагч, зохиолч хүний хөдөлмөрийг монгол
эмэгтэйчүүдийн уран үйл мэтгэхтэй адил нарийн ажил юм гэдгийг илэрхийлсэн байна. Ингээд:

. . . . Нутгийнхаа нүдэн нуурны
Намаг довыг бараадсан . . .
Нуурын замагны толбо
Нуруун дээр минь мөнхөрсөн
Нугын жаахан мэлхий байх юм би..⁹ гэж өөрийгөө мэлхий болгон
зүүдлээд, тэр нуурын хоёр бор галуу, амандаа саваа зууж, саваанаасаа мэлхийг үнхүүлээд,
өндөрт нисэн гарч буй тухай, "Энэ аргыг хэн олсон бол" хэмээн олны шагшин ярихыг сонсоод,
хөөрүү сэтгэлдээ "би" хэмээн хэлтэл:

. . . . Хөх тэнгэрийн гүнээс
Шидсэн чулуу шиг уналаа
Газар хүрэхийн алдад
Гайтай зүүднээс сэрж амарлаа . . .⁹ гэж монгол ардын аман зохиолын үлгэрийн
өгүүлэмжийг ашиглан, өөрийгөө буюу хүнийг мэлхий болгон дүрсэлсэн нь "Зохист аялгуун толь"
дахь үлгэрийн дүрст чимэгтэй тохирч байна. Энд, "Эрхэм эгэл хоёрыг адилтган, тэгэхдээ
дүрслэн өгүүлэх аргаар гаргахыг үлгэрийн дүрст чимэг гэнэ" гэсэн байдаг. Иймд "хүн" гэсэн
эрхэм зүйлийг эгэл нэгэн мэлхийтэй жишин, үлгэрийн сонин өгүүлэмжийг ашигласан нь
өвөрмөц юм.

"Зохист аялгуун толь"-д төгөлдрийн дүрст чимэг гэж бий. Үүнийг Х. Гааданы судалсан
Лувсанжамцын эхэд "Төгөлдөр гэдэг үгээр нэрийг гаргаж, нүүрийг цэцэг инээгээд бадарч буй
мэтээр, хөдлөх нүдийг нь зөгийгөөр дүрслэн, энэ хоёр хэрэглэгдэхүүн нэг газар оршихоор үл
барам хоёул нэг газар нөхцөлдсөн тул төгөлдөрийн дүрст чимэг гэнэ." Жишээ нь:

Янжинлхамын нуруун ороонго модны үзүүрт
Ятга хөхөө уран эгшигт дуугаа дуурсгана
Эрхэм тэргүүнд нь ургасан үсэн огторгуйд
Эрдэнэ чимгийн хурц гэрэл сайтар цацрав аа¹⁰ гэжээ. Үүнийг "Галын амьсгал" шүлэгтэй
харьцуулж үзвэл:

. . . . Гал өмнө минь амьсгалж байна
Үхсэн дайчдын үлдсэн амьсгал
Гал өмнө минь амьсгалж байна . . .
. . . . Нарны дуу гэрлээр цацарсан
Эгнэгт дэргэд нь хангинасан
Харууслын цэг
Чимчигнэн асах гал
Зүрх шиг лугшиж
Чин зоригт тэдний
Сүнс мэт дүрэлзэнэ
. . . . Энэ гал ассан цус
Энэ гал амьтай зул . . .¹¹ гэж "Гал-амьсгал", "цус-зул" зэргийг нэг газар оршиж,
нэгэн зүйлийг нөхцөлдүүлж буй мэтээр бичжээ.

⁸ Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991. Хуудас 93.

⁹ Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991. Хуудас 93.

¹⁰ Х. Гаадан. "Зохист аялгуун толин дахь адилтгал зүйрлэл". УБ, 1987. 2 бүлэг.

¹¹ Х. Гаадан. "Зохист аялгуун толин дахь адилтгал зүйрлэл". УБ, 1987. 2 бүлэг.

Эх орон ард түмнийхээ төлөө халуун амь, бүлээн цусаа хайрлахгүй баатарлагаар тулалдан эрсэдсэн, аавын олон хөвгүүдийг дурсаж мөнхийн галыг асаажээ. Энэ гал мөнх асаж, амьдарч буй тул амь эрсдэгчдийн амьдралын үргэлжлэл, тэдний "лугшсан зүрх нь", амьсгалсан "амьсгал" нь болж буй учраас "ассан цус-амьтай зул" билээ.

"Би нүүдлийн цахилгаан станц" шүлэгт:

Өдөр шөнөгүй эрчим хүч
Тархинаасаа уудлах . . .
Сэдвийг нүүрс шиг залгиж
Сэрэхүйн зууханд шатааж
Шүлэг болгон
Шөнийг сүлэх. . . .
Би цахилгаан станц
Арьсгүй гараар хорвоог тэмтэрч
Аль харанхуй руу судсаараа гэрэл өртөөлөх
Би цахилгаан станц...¹² хэмээн өөрийгөө амьгүйчлэн гүтгэжээ.

Хүний амьдралд, ялангуяа орчин үед чухал хэрэгцээтэй цахилгааныг түгээдэг станцаар өөрийгөө төлөөлүүлэхдээ, жирийн хүний ажиглаагүй шинэ зүйлийг түмэн олондоо түгээдэг яруу найрагч зохиолчдын нөр их хөдөлмөрийг магтсан ажээ.

Энэ нь "Зохист аялгуун толь" дахь найруулахын дүрст чимэгтэй тохирч байгаа бөгөөд энд "Хоёроос дээш чанар бүхий байдлыг найруулан өгүүлж байж дүрсэлсэн юмныхаа сайхныг гаргах аргыг найруулахын арга гэнэ" гэж тодорхойлсон байна.

Үнэхээр ч яруу найрагч хүн эгэл амьдралын гүнээс сэдвийг "нүүрс шиг" залгилан оюун ухаандаа боловсруулж, шүлгээ бүтээн түүнийгээ "харанхуй руу судсаараа гэрэл өртөөлөх" мэт ард түмэндээ түгээн сэтгэл оюуныг нь баясгаж өгдөг аугаа их авьяастан билээ.

Дээрх зүйлүүдээс дүгнэлт хийн үзвэл, яруу найрагч Б. Лхагвасүрэн өөрийн уран бүтээлдээ дорнын уламжлалыг ашиглан, ингэхдээ үндэснийхээ өвөрмөц онцлогийг бараг шүлэг бүрт тусгасан нь (Тухайлбал, байгалийн байдал, адуун сүрэг гэх мэт) монгол хүний сэтгэхүйд буухуйц үнэмшилтэй болж өгсөн байна.

Ер нь яруу найрагчид, зохиолчид эхлээд яруу найргийг эсвэл утга зохиолын онолыг судалж байж зохиол бүтээлээ туурвидаггүй. Харин өөрсдийн авьяас билэг, амьдралын туршлага, билгийн хараа, нөр их хөдөлмөрөөрөө өөрийн уран бүтээлийг бүтээдэг. Ийм учраас Б. Лхагвасүрэнгийн зарим нэг шүлгүүдэд яруу найргийн онолын үүднээс бага ч болов зүйлийг зөвхөн "Гүтгэх"-ийн хүрээнд авч харьцуулан үзэхэд дээрх сонирхолтой зүйлүүд ажиглагдаж байна. Бусад яруу найрагчид, мөн уг яруу найрагчийн (Б. Лхагвасүрэн) бүтээлийг нарийвчлан судалбал үүнээс ч илүү өвөрмөц сонирхолтой зүйлүүд гарч ирэх нь дамжиггүй.

¹² Б. Лхагвасүрэн. "Хос уянга". УБ, 1991. Хуудас 92.

SUMMARY

Drawing a conclusion, B. Lkhagvasuren, a poet used the oriental tradition in his works. Also national feature is observed from almost poems of his. It can be easy to understand for mongolian people.

НОМ ЗҮЙ

1. Б. Лхагвасүрэн. "Хос уянга" түүвэр. УБ. 1991 он.
2. Д. Галбаатар. "Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь". Токио. 2002 он.
3. Д. Цэнд. "Яруу найраг ба шүүмжлэл". УБ. 2001 он.
4. Д. Цэрэнсодном. "Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал". УБ. 1978 он.
5. Х. Гаадан. "Зохист аялгуун толин дахь адилтгал зүйрлэл". УБ. 1987.
6. Х. Сампилдэндэв. "Яруу найргийн шинэ төлөв". УБ. 1990 он.